# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 01 өдөр Дугаар 214 Улаанбаатар хот

Нийслэлийн өмчөөс 2025 онд
хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг
зөвшилцөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийслэлийн өмчөөс 2025 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг хавсралт ёсоор дэмжсүгэй.

2.Жагсаалтад заасан эд хөрөнгийг хувьчлах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу зохион байгуулж, дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2025 оны 4 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчийн хуралд зөвлөмж болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132000730

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 214 дүгээр тогтоолын хавсралт

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧӨӨС 2025 ОНД ХУВЬЧЛАХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Хувьчлах эд хөрөнгийн нэр | Эд хөрөнгийн олж авсан арга, хэлбэр, эрх зүйн акт, дугаар, огноо | Байршил | Хувьчлах эд хөрөнгийн үйл ажиллагааны чиглэл, үл хөдлөх хөрөнгийн зориулалт | Талбайн хэмжээ (м.кв) | Хувьчлах эд хөрөнгийн дүн (ААН бол нийт хөрөнгөөс өр төлбөр хассан дүнгээр, үл хөдлөх хөрөнгө бол балансын үлдэгдэл үнэ) (мян.төг) | Хувьчлах хугацаа | Хувьчлах арга, хэлбэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Шуудангийн 24 дүгээр салбар байрлаж байсан байр | 1981 он | БГД, 14-р хороо | Түрээсийн гэрээгээр гар утасны худалдаа явуулдаг | 198 м² | 124,296.1 | 2025 он | Нээлттэй дуудлагын худалдаа |
| 2 | “Эрхэмжаргалан” Өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга | 2004 он | БГД, 7-р хороо | Ашиглалтгүй | 108 м² | 50,198.40 | 2025 он | Нээлттэй дуудлагын худалдаа |
| 3 | БЗД-ийн 4-р хорооны хуучин байр | 1966 он | БЗД, 4-р хороо | Түрээсийн гэрээгээр иргэнд түрээслүүлдэг. | 46 м² | 39,489.61 | 2025 он | Нээлттэй дуудлагын худалдаа |
| 4 | Хүүхдийн сүүний цэг /Ачит гар/ | 1970 он | СБД, 2-р хороо | Ашиглалтгүй | 64.14 м² | 45,685.55 | 2025 он | Нээлттэй дуудлагын худалдаа |
| 5 | БЗД-ийн 7-р хорооны хуучин байр | 1990 он | БЗД, 7-р хороо | Ашиглалтгүй | 33 м² | 20,864.02 | 2025 он | Нээлттэй дуудлагын худалдаа |
| 6 | СХД, 21-р хорооны өрхийн эмнэлэг | 2007 он | СХД, 21-р хороо | Ашиглалтгүй | 108 м² | 47,370.45 | 2025 он | Нээлттэй дуудлагын худалдаа |
| 7 | Сүврага Налайх Өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга | 2013 он | НД, 4-р хороо | Ашиглалтгүй | 287.3 м² | 43,923.60 | 2025 он | Нээлттэй дуудлагын худалдаа |
| 8 | Тэрэлж нийтийн бие засах байр | 2018 он | НД, 6-р хороо | Ашиглалтгүй | 7,26 м² | 9,970.21 | 2025 он | Нээлттэй дуудлагын худалдаа |
| 9 | Халуун усны барилга | 2009 он | СХД, 7-р хороо | Ашиглалтгүй | 80 м² | 32,656.07 | 2025 он | Нээлттэй дуудлагын худалдаа |

.....................оОо.......................